

УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА, ГАДААДЫН
ИРГЭН, ХАРЬЯАТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ АЛБАНЫ ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2008 оны 01 дугаар
сарын 09-ны өдөр

№ 08 /30

Улаанбаатар
хот

Журам батлах тухай


Төрийн хяналт шалгалтын тухай, Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулиуд, Мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм болон бусад гадаадын иргэн, иргэний харьяаллын асуудлаарх хууль тогтоомжийн актыг хэрэгжүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын Агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын мэргэжлийн хяналтын газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны хамтран ажиллах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Улсын мэргэжлийн хяналтын газрын Тамгын газрын дарга /Н.Бямбадорж/, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны Захиргааны удирдлагын хэлтсийн дарга /А.Энх-Эрдэнэ/ нарт даалгасугай.

УЛСЫН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТБААТАР

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ АЛБАНЫ ДАРГА
Д.МӨРӨН



УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР, ГАДААДЫН
ИРГЭН, ХАРЬЯАТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ АЛБАНЫ
ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Улсын мэргэжлийн хяналтын газар болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба чиг үүргээ хэрэгжүүлэхэд харилцан туслах, мэдээлэл солилцох, хамтарсан шалгалт хийх, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2. Улсын мэргэжлийн хяналтын газар болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба нь үйл ажиллагаандаа Төрийн хяналт, шалгалтын тухай, Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журмыг Улсын мэргэжлийн хяналтын газар /цаашид "газар" гэх/, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба /цаашид "алба" гэх/ дагаж мөрдөнө.

1.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж, хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэн, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хүрээнд харилцан туслах зарчмыг баримтлан хамтран ажиллана.

1.5. Аливаа асуудлыг удирдлагын түвшинд шийдвэрлэж албан бичиг болон электрон хэлбэрээр мэдээллийг солилцоно.

1.6. Хамтран гүйцэтгэх шалгалтын үндсэн чиглэлийг урьдчилан тохиролцож тус тусын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж болно.

Хоёр. Улсын мэргэжлийн хяналтын газрын
хамтын ажиллагаа

2.1 Газар нь харилцан туслах, хамтран ажиллах хүрээнд дараахи эрх үүргийг хүлээнэ.

2.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж, хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэн, байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих зөвшөөрөл авч, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих,

2.1.2. Хяналт шалгалтын явцад гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбоотой илэрсэн зөрчлийг шийдвэрлүүлэхээр Албанд шилжүүлэх,

2.1.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбоотой асуудлаар харилцан мэдээлэл солилцож, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтыг хамтран гүйцэтгэх,

2.1.4. Албанаас шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэний асуудлыг хэдийд, хэрхэн шийдвэрлэсэн талаархи мэдээг тухай бүр Албанд ирүүлж байх,

2.1.5. Шаардлагатай бусад асуудлаар хамтран ажиллах,

Гурав. Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх албаны
хамтын ажиллагаа

3.1. Алба нь харилцан туслах хамтран ажиллах хүрээнд дараахи эрх үүргийг хүлээнэ:

3.1.1. Монгол Улсад хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэнийг илрүүлэн хууль тогтоомжийн дагуу ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлэхээр Газарт хүргүүлэх,

3.1.2. Шаардлагатай тохиолдолд хамтран үзлэг, шалгалт зохион байгуулж, шалгалтын дүнг хамтарсан хурал зөвлөлгөөнөөр шийдвэрлэх,

3.1.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбоотой мэдээллийг тухай бүр Газарт хүргүүлэх,

3.1.4. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруурахгүй байх,

3.1.5. Газраас хийж буй хяналт шалгалтын ажилд шаардлагатай тусалцааг цаг тухайд нь үзүүлэх,

3.1.6. Газраас Албанд тавьсан асуудлыг хэдийд, хэрхэн шийдвэрлэсэн талаар тухай бүр хариу мэдээлэх,

Дөрөв. Хамтарсан шалгалт явуулах

4.1. Аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэний Монгол Улсын хууль тогтоомжийн биелэлтийн талаар хийх хамтарсан шалгалтыг хоёр байгууллагын даргын хамтарсан удирдамж батлуулан зохион байгуулна.

4.2. Хамтарсан шалгалт зохион байгуулахад түүнтэй холбогдон гарах зардал, техник хэрэгслийг шалгалт явуулах удирдамжаар тухай бүр зохицуулна.

4.3. Шалгалтын үр дүнгийн талаар шалгалтыг гүйцэтгэсэн албан хаагчид тус тусын байгууллагын удирдлагад илтгэх хуудсаар танилцуулан чиглэл авна.

4.4. Хамтарсан шалгалт болон түүний үр дүнтэй холбоотой байгууллагын нууцыг мэдэж байгаа төрийн албан хаагч түүнийг задруулах болон хувийн зорилгод ашиглахыг хориглоно.

Тав. Бусад зүйл

5.1. Хоёр байгууллагын хооронд бий болсон аливаа бэрхшээлтэй байгууллагын эрх ашиг хөндсөн асуудал, журамд нэмэлт өөрчлөлт оруулах болон түүний үйлчлэлийг зогсоохтой холбоотой аливаа асуудлыг байгууллагуудын удирдлагын түвшинд тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж байна.

5.2. Газар, Албаны удирдлагын хамтарсан зөвлөлгөөнийг жилд нэг удаа зохион байгуулна.

5.3. Байгууллага хооронд солилцсон мэдээллийг зөвхөн албаны хэрэгцээнд ашиглаж, "Байгууллагын нууцын тухай" болон "Хувь хүний нууцын тухай" Монгол Улсын хуулийг сахин биелүүлнэ.

5.4. Хоёр талын хамтын ажиллагааны явцад нууцлалын зарчмыг чанд баримталж ажиллах бөгөөд мэдээллийн нууцыг задруулсан, хувийн ашиг сонирхолд ашигласан, хуурамч мэдээлэл өгсөн төрийн албан хаагчид Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу түүнийг харьяалах байгууллагын удирдлага хариуцлага хүлээлгэнэ.